

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

“Эмийн цэцэглэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/02/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Battsogtd@audit.gov.mn">Battsogtd@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a> Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:ganbaatarz@audit.gov.mn">ganbaatarz@audit.gov.mn</a>
--------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.15 № 322

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ЭМИЙН ЦЭЦЭГЛЭН ӨРХИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Э.ЭНХЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эмийн цэцэглэн" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Эмийн цэцэглэн" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган аймгийн Засаг даргын тамгын газраас тус Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гурвалсан гэрээний хэрэгжилтийг 2024 онд хангалтгүй гэж дүгнэсэнд Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулахад Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/321 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам"-д нийцүүлэн сонгон шалгаруулалт явуулан "ТАНСРАЖИД" ЗБН-ийг сонгон шалруулалтанд тэнцсэнд мэдэгдэл хүргүүлсэн.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгааснаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6300250501

### **Бусад асуудлын хэсэг**

"Эмийн цэцэглэн" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан байгууллагын 2025 онд гурвалсан гэрээг байгуулан гүйцэтгэлийг хангалтгүй дүгнүүлсэн байна.

"Эмийн цэцэглэн" Өрхийн эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	58,482.45	28,328.41
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	255,236.65	212,986.61
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>313,719.10</b>	<b>241,315.02</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	5,473.22
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	313,719.10	235,841.80
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>313,719.10</b>	<b>241,315.02</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	465,883.15	456,673.53
	Үйл ажиллагааны зардлын дүн	433,252.57	503,090.83
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>32,630.58</b>	<b>(46,417.30)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(31,460.00)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>32,630.58</b>	<b>(77,877.30)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	313,719,099.46
	Тайлант оны үр дүн	-	(77,877,299.88)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>313,719.10</b>	<b>235,841.80</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	378,649.29	439,823.53
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	375,784.55	439,748.76
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>2,864.74</b>	<b>74.78</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-</b>	<b>(2,950.00)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,864.74</b>	<b>(2,875.22)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,899.46
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,899.46	24.24
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>375,784.55</b>	<b>439,748.76</b>
	Урсгал зардал	375,784.55	439,748.76
	Хөрөнгийн зардал	-	2,950.00
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>378,649.29</b>	<b>439,823.53</b>
	Улсын төсвөөс санхүүжих	353,783.29	376,992.93
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	250.00	37,830.60

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,650.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 зөвлөмж 1,650.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа..

#### 5.1 Төлбөрийн акт Байхгүй

#### 5.2 Албан шаардлага

- ✓ Тайлан онд эрүүл мэндийн сайдын тушаалаар Өөрчлөлтгүй дүгнэлт авсан нягтлан бодогчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосон байна.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## Цалинтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:1** тайлан онд нэг албан хаагчид тусламж үйлчилгээний орлогоос урамшууллыг олгохдоо тушаал шийдвэрийн үндэслэлийг буруу тодорхойлсон.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зардалд зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлан онд эрүүл мэндийн сайдын тушаалаар Өөрчлөлтгүй дүгнэлт авсан нягтлан бодогчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосон байна.	1	1,650.0			1	1,650.0						
тайлан онд нэг албан хаагчид тусламж үйлчилгээний орлогоос урамшууллыг олгохдоо тушаал шийдвэрийн үндэслэлийг буруу тодорхойлсон.	1	-					1	-				